



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтын 1-т заасан хуулийн этгээдийн “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 2-т заасан хуулийн этгээдийн “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

Ө.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн
138 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдийн
жагсаалт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөр- лийн дугаар	Тусгай зөвшөөр- лийн хугацаа	Хамрах хүрээ, үйлчилгээний хүртээмж
1	Нэйшнл ньюс корпорэйшн ХХК /Блүүмберг суваг/	12900040	2023.12.06 2028.12.06	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх”
2	Эн Би Си ХХК	13400045	2023.12.20 2028.12.20	Улаанбаатар хот болон Налайх дүүргийн нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх”

----- оОо -----